



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2025. 02. 25

№

01/278

танай

-ны №

-т

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА П.БАЯНБААТАР  
ТАНАА

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн  
Төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг  
хүргүүлж байна.

Аудитын зөвлөмжийн мөрөөр авч  
хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын  
тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор  
төрийн аудитын байгууллагад ирүүлэхийг зөвлөж  
байна.

Хавсралт . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

М.ЭРДЭНЭЖАРГАЛ



02024286



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025, 02.25 № 04/243  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ  
ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
БӨГӨӨД ХУРЛЫН АЖЛЫН  
АЛБАНЫ ДАРГА  
П.БАЯНБААТАР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төсвийн шууд захирагч нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn болон шилэн дансны системд ил тодоор мэдээлэл байршуулаагүй, тайлант оны худалдан авалтын захиалга хүсэлт хүргүүлээгүй, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

### Аудитын гол асуудал

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төсвийн төслийг боловсруулахдаа тухайн орон нутгийн хэрэгцээ шаардлагыг судалж, нөхцөл байдал, эрсдэлийг үнэлээгүй, шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй, 1,082,559.3 мянган төгрөгийн төсөв баталж, салбар зөвлөлд харьяалагдах байгууллагуудаар дамжуулан зарцуулсан байна.

Тайлант онд 4,234,223.8 мянган төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд түүнд 2 удаа тодотгол хийж, 22.4 хувиар нэмэгдүүлж, нийт 5,181,521.7 мянган төгрөгөөр баталжээ. Үйл ажиллагаандаа 5,143,107.1 мянган төгрөгийн төсөв зарцуулсан нь өмнөх онтой харьцуулахад 55.4 хувиар өссөн байна.

## **Бусад асуудал**

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92.7 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна. Тайлант онд хэвлэл мэдээллийн 5 байгууллагатай гэрээ байгуулан 28,836.5 мянган төгрөгийг байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулахад зарцуулжээ.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

